



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 24 өдөр

Дугаар А/47

Хэрлэн сум

Арга хэмжээнд оролцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.6-ын "а", Монгол улсын Засгийн газрын 2018 оны 260 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь.

1. Монгол улсын "Аялал жуулчлалын хөгжлийн төв" Төрийн өмчит үйлдвэрийн газар, Бүгд Найрамдах Солонгос улсын орон нутгийн албан хаагчдын хөгжлийн институттэй хамтран 2019 оны 02 дугаар сарын 17-ноос 24-ний хооронд Бүгд Найрамдах Солонгос улсын Чонжү хотод зохион байгуулагдах 7 хоногийн сургалт семинарт Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга Ч.Баярцолмон, Татварын хэлтсийн Эрсдэл статистикийн хэлтсийн тасгийн дарга, татварын хэлтсийн улсын ахлах байцаагч Г.Энх-Амгалан, Татварын хэлтсийн улсын байцаагч Г.Баянзул нарыг тус тус оролцуулсугай.

2. Гадаад томилолттой холбоотой бэлтгэл ажлыг зохион байгуулахыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн Захиргааны удирдлагын хэлтсийн дарга Ж.Гантулгад даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА